

ХЯТАДЫН ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГО

З.Цолмонбаяр*

Оршил


Хятад улс 1978 оноос эхлэн “эдийн засгийн нээлттэй” бодлогыг гадаад худалдааны оновчтой бодлоготой хослуулан хэрэгжүүлснээр эдийн засгийн өндөр, тогтвортой өсөлтийг хангаж чаджээ. Гадаад худалдааны статистикийг харахад 1993 оноос эхлэн Хятад газрын тосны цэвэр импортлогч орон болсон бөгөөд 2003 оноос хойш АНУ-ын дараа орох дэлхийн хоёр дахь нефть импортлогч, хэрэглэгч орон болон хувирлаа. Нефтийн жилийн хэрэглээ нь 250 сая тоннд хүрч, бүс нутаг болоод дэлхийн эрчим хүч, худалдаа, санхүүгийн урсгалд хүчтэй нөлөө үзүүлэх боллоо. 2003 онд Хятад улс дэлхийн зах зээл дээрээс 91.12 сая тонн нефть импортлосноос харахад гадаад зах зээлээс 35 хувийн хамааралтай байгаа бөгөөд нийт нөөцөлж чадах түүхий нефтийн хэмжээг тооцож үзвэл 21,6 хоногийн нөөцтэй байна. Энэ нөхцөл байдал нь өөрийн эрхгүй Хятадыг эрчим хүчний дипломат арга ажиллагаа руу түлхэж байна. Энэ нь Ху

Жиньтао төр засгийн дээд удирдлагад гарснаас хойш хийсэн 14 айлчлалын 6 нь энэ асуудалтай холбоотой байгаагаас харахад илэрхий юм. Ийнхүү өндөр хурдтайгаар өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлт хэрэгцээг хэрхэн найдвартай хангах вэ? гэдэг асуудлыг яаж шийдвэрлэх нь зөвхөн Хятад улсын өмнө тулгамдаад зогсохгүй Ази номхон далайн бүс нутгийн орнууд болоод дэлхийн их гүрнүүдийн анхаарлын төвд байна.

Эрчим хүчний эх үүсвэрийн бүтэц, хэтийн төлөв

Хэдийгээр Хятад улсын эрчим хүчний голлох хэрэглээ нүүрсэнд түшиглэсэн хэвээр байх боловч газрын тосны импорт нь стратегийн шинж чанараараа Хятадын эрх баригчдын байнгын анхааралд байдаг чухал асуудлуудын нэг юм. Эдийн засгийн өсөлт одоогийнх шиг 7 хувиас өндөр түвшинд хадгалагдсан тохиолдолд нефтийн импорт 2005 он гэхэд нийт хэрэглээнийх нь 30-35%, 2010 гэхэд 45%-д хүрэх юм¹. Хятад улсын газрын

Хятадын эрчим хүчний хэрэглээний багц, 2001 он¹



* З.Цолмонбаяр. МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн магистрант

¹ www.auswaertiges-amt.de/www/de/infoservice/download/pdf/planungsstab/china_round_table/4-oberheitmann.pdf

тосны хэрэглээ 2000 онд өдөрт 4.78 сая баррель байсан бол 2002 онд 4.9 сая баррелийг хэрэглэсэн байна. 2010 гэхэд өөрийн газрын тосны хэрэгцээний тал хувийг буюу өдөрт 3-4 сая баррель нефть импортлох зайлшгүй шаардлагатай тулгараад байгаа тул Хятад улс газрын тосны асуудалд ихээхэн анхааралтай хандах болсон.

Дотоод нөөц боломж, ашиглалт

Хятадын нефть олборлогч дотоодын гурван гол эх үүсвэр нь Дацин-Шэнли-Ляхэгийн сав болон Синьзян мужийн газрын тосны орд газар, Зүүн Хятадын тэнгис орчмын далайн ёроолын газрын тосны орд газрууд юм.

Одоогоор Дацин-Шэнли-Ляхэгийн орд газрын нөөц бага болсон тул Синьзяны сав газар дахь Тарим, Жунгар болон Ту Ха ордууд нь хамгийн чухалд тооцогдож байна. Хэдий тийм боловч эдгээр орд нь олборлоход уулархаг газар оршдог, геологийн хүндрэлтэй, олборлолтын орчин үеийн технологи шаардлагатай зэрэгцээ үйлдвэрлэлийн зардал ихтэй, хөрөнгө оруулалтын хувьд эрсдэлтэйд тооцогдож байгаа юм.

Дотооддоо олборлож байгаа нефтийнхээ 10 гаруй хувийг Зүүн Хятадын тэнгис орчмын далайн ёроолын газрын тосны ордоос авдаг бөгөөд олборлолтын зардал нь Хятадын аль ч газрын гүний ордын олборлолтын зардлаас хавьгүй өндөр учир үйлдвэрлэлийн хувьд үр ашиггүйд тооцогдож байна. Энэ орд газар нь зардал өндөртэйгээс гадна хилийн маргаантай байгаа. Тухайлбал, энэ 10 сарын дундуур Вьетнам, Малайз, Сингапур, АНУ-ын хамтарсан хайгуулын дүнд өмнөд хятадын тэнгист газрын тосны шинэ орд нээн илрүүлж, 181 сая баррелийн нөөцтэй хэмээн урьдчилан тооцжээ. Энэ талаар Хятадын Гадаад хэргийн яам “Хятад үүнд маш анхааралтай хандаж байгаа бөгөөд сэтгэл

дундуур байна. Нанься арлууд болон ойр орчмын ус нь Хятадын газар нутгийн салшгүй хэсэг бөгөөд вьетнамчуудын энэ алхам нь Хятадын тусгаар тогнол, далайн эрхийг хөсөрдүүлсэн зүйл юм. Ханой энэ алдаагаа засах хэрэгтэй. Тэнд ажиллаж байгаа компаниуд үйл ажиллагаагаа зогсоо” гэж мэдэгдсэн². Уул нь 2002 онд АСЕАН-ны уулзалт дээр өмнөд Хятадын тэнгис дэх маргаантай хэсгийн статус-квог хүлээн зөвшөөрсөн боловч нэг жилийн дараа Хятадын тал амлалтаасаа буцсан юм. Үүнтэй төстэй маргаан 1980-аад оны сүүлчээр өрнөж 1988, 1992 онд Хятад, Вьетнам хоёр улс мөргөлдөж байжээ.

Хятад улс газрын тосны импортын талаар шинэ стратеги боловсруулж хэрэгжүүлсний дотор газрын тосны импортын талаар чанд бодлого явуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадахуйц, санхүүгийн чадвар сайтай хүчирхэг газрын тосны компаниудыг байгуулсан. Энэ арга хэмжээний хүрээнд CNPC -Хятадын Үндэсний Газрын Тосны Корпораци, SINOPEC-Хятадын Үндэсний Далайн Гүний Газрын Тосны Корпораци, SINOPEC-Хятадын Үндэсний Газрын Тос, Химийн үйлдвэрийн Корпораци зэрэг улсын өмчит гурван том компанийг Засгийн газрын яамны түвшинд үйл ажиллагаагаа явуулах эрхтэйгээр байгуулж Улсын эдийн засаг худалдааны хороонд шууд харьяалуулсан. Эдгээр нь яамны түвшингийн компаниуд тул гадаад улсад газрын тосны үйл ажиллагаа явуулах болон түрээслэх эрх худалдан авах, гадаадад газрын тос олборлох охин компани байгуулах эрхтэй юм. Дээрхи компануудын үйл ажиллагаа явуулах бүс нутгийг газар зүйн хувьд хуваасан бөгөөд CNPC компани нь өрнөд болон умардад, SINOPEC компани нь өмнөдөд үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тэдгээр газрын тосны компаниуд 2005 онд хийх хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмж байгаа бөгөөд CNPC 10.6 тэрбум, SINOPEC

² http://atimes.com/atimes/Southeast_Asia/FJ27Ae02.html

6.1 тэрбум, СНООС 2.2 тэрбум ам долларт хүргэхээр төлөвлөөд байна. Ийнхүү дотоод нөөц боломжууд нь зардал ихтэй, хязгаарлагдмал байгаа учир Хятад улс Дэлхийн нефтийн үйлдвэрлэгчидтэй харилцан ойртож ажиллахаар чармайж байна.

Гадаад дахь дипломат ажиллагаанууд

Гадаад бодлогын хувьд Хятад улс дэлхийн газрын тосны томоохон үйлдвэрлэгчдээс Ойрхи Дорнод, Орос, Төв Ази гэсэн 3 бүс нутагтай хамтран ажиллахыг хүсч байна.

Ойрхи Дорнод ба Хятад

Хятад улс 1970-аад оны үеэс л газрын тосны баялаг ихтэй Ойрхи Дорнодыг сонирхох болсон бөгөөд энэ бүс нутгаас газрын тосны импортынхоо дийлэнх хэсгийг авдаг. Энэ оны 7 сарын эхээр Персийн Булангийн Хамтын ажиллагааны Консулын гишүүн 6 улсын сангийн яамны төлөөлөгчидтэй уулзаж чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаад байна.

Тус бүс нутаг дахь Хятадын гол түншүүд нь Иран, Ирак улсууд юм. Иракийн нутаг дэвсгэр дээр газрын тосны олборлолт явуулахаар 1997 онд Ирак улсаас худалдан авсан эрх болон авахаар сонирхож буй газрын тосны ордуудыг НҮБ-аас Иракийн эсрэг тавьсан хориг цуцлагдсан тэр цагт л ашиглаж болох юм. Ийм учраас дээрхи хоригийг аль болох хурдан цуцлуулах нь Хятадын эрх ашигт нийцэх бөгөөд энэ хоригийг цуцлуулах талаар Хятад улс НҮБ-д удаа дараа байр сууриа илэрхийлж байсан юм.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон санкцын асуудал эрхэлсэн НҮБ-ын бусад байгууллага дахь Хятад улсын байр суурь нь Ирактай хийсэн газрын тосны наймаанд голлох үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Орос ба Хятад

1994 онд ОХУ-ын Юкос компани Хятадтай хамтран Хятад-Оросын нефтийн хоолойн талаар ярилцсаны эцэст 2001 оны 9 сард гэрээнд гарын үсэг зурсан. Дараагийн 2 жилд нь Ангарск, Дацингийн чиглэлийн нефтийн хоолойн судалгаа хийхээр тохирсон бөгөөд байгуулалтын ажил эхлэхээр яригдаж байх үед буюу 2002 оны сүүлчээр ОХУ-ын Транснефть компани Ангарск-Находка чиглэлийг санал болгосон. Энэ чиглэлийг барихад Япон 14.5 тэрбум ам.доллар амлахаас гадна Сахалин-1, Сахалин-2 газрын тос, байгалийн хийн төсөлд 8 тэрбум ам.доллар өгөхөөр амлаад байна.



2003 оны 9-р сард ОХУ-ын Байгалийн нөөцийн сайд Ангарск-Находка чиглэлийг сайшааж, нөгөө чиглэл нь Байгал нуурийн экологид хортой гэж мэдэгдсэн. 2004 оны 2-р сард Путин “Оросын засгийн газар нефтийн хоолойг Номхон Далайд хүргэх сонирхолтой байсан учир Ангарск-Находка чиглэл стратегийн ач холбогдолтой байлаа” гэснээр энэ төсөл үндсэндээ зогсчээ. Гэтэл 2004 оны 3-р сард Транснефтиэс дахин шинээр Тайшет-Находка чиглэлийг санал болгоод байна.



2004 оны 6-р сарын 30-нд ОХУ-д суугаа Хятадын элчин сайд Оросын Аж үйлдвэр, эрчим хүчний сайд Виктор Криштенкотой уулзахад Криштенко эхний үед яригдаж байсан хоёр чиглэл экологийн асуудлаас үүдээд хэрэгжилгүй хойшлогдоод байгаа, харин Тайшет-Находка чиглэл хамгийн боломжтой нь байна гэж мэдэгдсэн. Энэ чиглэл нь Байгал нуураас 225 км зайтай, Ангарск-Находка чиглэлээс 150 км хойгуур даялж тавигдана. Транснефтийнхний энэ чиглэл нь Путиний зүүн Сибирь, Алс Дорнодыг хөгжүүлэх бодлоготой нийцэж байгаа гэжээ. Энэ хоолой нь жилд 80 сая тонн нефть дамжуулах, үүнээс 50 сая нь Находкаар дамжаад Зүүн Хойд Ази руу, 30 сая нь Хятад руу дамжихаар хийгдэх төлөвлөгөөг оросууд хийгээд байна. Энэ чиглэл нь Номхон далайд хүрэх, Япон, Хятад, БНСУ, БНАСАУ, АНУ зэрэгт нефть нийлүүлэх стратегийн ач холбогдолтой боловч эцсийн шийдвэрийг гаргахгүй удаад байгаа нь Оросын зүгээс Хятадад илүү анхаарал хандуулж байгааг илэрхийлж байна.

Төв Ази ба Хятад

Каспийн тэнгисийн эрэг орчмын газрын тосны нөөц нь маш их ирээдүйтэйд тооцогдож байна. Энэ бүс нутгийн улсуудаас

Хятадтай хуурай газраар хиллэсэн, ойр байрлах улс нь Казахстан учир Хятадын эрх баригчдын сонирхол энэ зүгт хандаж байна. Казахстаны ерөнхийлөгч Н.Назарбаев Бээжинд айлчлах үеэр Ху Жиньтао: “Казахстан Хятад хоёрын геополитикийн ашиг сонирхол нэгэн ижил” гэж хэлсэн бол Н.Назарбаев “Хятадын хөгжил манай улсад дайсагнахгүй учир бид хамтран ажиллана” гэж мэдэгдсэнээс харахад Казахстаны зүгээс Хятадын зах зээлийг сонирхож байгаа, харин Хятадын зүгээс геополитикийн сонирхлоо нийлүүлэх гэсэн оролдлого гарч байна. Хятадаас Казахстанд газрын тосны чиглэлээр нилээд хэмжээний хөрөнгө оруулалт хийгдээд байгаа ч зарим бэрхшээлүүд тохиолдож байна. Учир нь ихэнх газрын тосны компаниуд өрнөдийнхний гарт орсон байдгаас шинээр зах зээлд нэвтрэхэд хүндрэлтэй байгаа. 1997 онд тавигдсан Казахстанас Синьзян хүртэлх 1000 гаруй км хоолойн ажил нь АНУ-ын шахалтаар зогсоход хүрч байв. Казахстаны ерөнхийлөгч Н.Назарбаев 2004 оны 5-р сард БНХАУ-д айлчлах үеэр Атасу-Алашанькоугийн нефть дамжуулах 1000 орчим км урт хоолойг ойрын 2 жилийн байгуулах талаар тохиролцон гэрээ байгуулсан юм. Хятадын 2 ба 3-р компаниуд 2003 онд хамтран Казахстаны Каспийн сав газар дахь нефтийн ордыг худалдан авсан боловч өрнөдийнхөн бүлэглэн шахаж байна.

Эцэст нь хэлэхэд манай урд хөршийн газрын тосны чиглэлээр барих гол стратеги нь “Дэлхийд газрын тос байна, бидэнд мөнгө байна” гэсэн засгийн газрын албан ёсны төлөөлөгчийнх нь мэдэгдэл байх төлөвтэй байна. Манай улсад Зүүн баян болон Тамсагийн сав газарт газрын тосны хайгуулыг Хятадын хөрөнгө оруулалттайгаар хийж, түүхий нефтээ Хятад руу экспортлож байна. Энэ сав газрын геологийн орчин нь сайн, олборлох зардал багатай учир нөөц хангалттай бол бид түүхий нефть боловсруулах үйлдвэрийг барихад ашигтай байх болно.